



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ~~20~~ он ~~05~~ дугаар
сарын ~~26~~ ны өдөр

Дугаар ~~437~~/1385

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.ПҮРЭВДОРЖ
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Я.ОЮУН-ЭРДЭНЭ

2058437

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн санаачлан боловсруулсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн санаачлан боловсруулсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэн орсноор Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 24 дүгээр бүлгийн HS2403.19.20 үндэсний код бүхий янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхинд ногдуулах импортын барааны гаалийн тарифын хувь, хэмжээний дээд хязгаарыг 20 хувиас хэтрүүлэхгүй байх үүрэг хүлээх болсон. Тогтоолын төслийн 1-д зааснаар HS2403.19.20 үндэсний код бүхий тамхинд ногдуулах импортын барааны гаалийн тарифын хувь, хэмжээг “30” болгон өөрчлөх нь дээр дурдсан Монгол Улсын хүлээсэн үүргийг зөрчихөөр байх тул олон улсын баримт бичигт нийцүүлэн импортын гаалийн тарифын хувь, хэмжээг “20” хувиас хэтрүүлэхгүй байх;

2. Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.11-д “шинэ төрлийн татвар бий болгохгүй” гэж заасан тул тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацааг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоох.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР